



**ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын тайлан

*ТАБ-ын Дарга, тэргүүлэх
аудитор*

Л.Жаргалсайхан

И-мэйл:

jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Шинжээч

А.Батлхагва

Утас: 70272248 96011185

G-Мэйл: batlhagva617@gmail.com

Аймгийн аудитын газрын хаяг: 2017 оны 2 дугаар сар 25

Төв аймаг Зуунмод сум 6-р баг

Төрийн байгууллагуудын 2-р

ордон

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Татварын хэлтсийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2017/7/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Татварын хэлтсийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарт нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн шинжээч А.Батлхагва хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Татварын хэлтэс нь 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 18-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25 -нд Төв аймгийн Татварын хэлтсийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн шууд захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын хууль гэх мэт хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төв аймгийн Татварын хэлтэс нь “Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино” гэсэн зорилготой бөгөөд 2016 онд :

1. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах.
2. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих.
3. Улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх. гэсэн зорилтууд тавин ажилласан байна.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу төсвөөс санхүүжилт авч байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасан, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн Дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-Б-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Татварын хэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 10 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичгийг УСНББОУС, санхүүгийн бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журам зааварт нийцүүлэн боловсруулан батлуулж мөрдөж ажиллах гэсэн хэрэгжүүлээгүй байна.

Татварын хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2013.12.02-ний өдрийн 269-р тушаалаар нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт орсон өөрчлөлт, түүнийг мөрдөх аргачлал, ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон зэргийг тусгаж шинэчлэгдээгүй байна. Emerald програм ашигладаг байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг үнэлсэн тус байгууллага нь дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 625568.4 мянган төгрөгийн санхүүжилт аван. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 624996.4 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 571.9 мянган төгрөгөөр хэмнэснийг төсөвт татан төвлөрүүлснийг мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан ба 2016 оны мэдээллээ цаг хугацандаа сайтанд сар бүр мэдээллийг байршуулан хэтрэлт хэмнэлт гарсан тухай бүр байршуулан ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 дансанд 11 уламжлалт эрсдэлийг, 6 дансанд 9 хяналтын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 11 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан горим сорил нь тус байгууллагын мөнгөн хөрөнгийн нийт зарлагын 100 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 19026.0 мянган төгрөгийн түлш халаалт, цэвэр, бохир усны төлбөрийг байгууллагын дансанд шилжүүлээгүй Төв Чандмань ДЭХГ-ийн НӨАТ-н өглөгөнд шилжүүлэн авдаг зөрчил илэрсэн. Энэ нь "Төсвийн тухай хуулийн" бдугаар зүйлийн 6.5.4 Төсвийн

захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх, барьцаалахгүй байх. 16 дугаар зүйлийн 16.5.5-д Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 13дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 20 дугаар зүйлийн 20.1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид гаргахгүй байхыг анхааруулж албан шаардлага бичив.

2. Байгууллагын ажиллагсадын өмчилсэн зуслангийн газарт төсвийн хөрөнгөөр 20250.0 мянган төгрөгийн хашааг барин үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн: Хариуцсан 24 ажилтан албан хаагч нараар хашааны үнийг барагдуулах талаар холбогдох шатны байгууллагад хүсэлт гарган шийдэрлүүлэхээр зөвлөмж хүргүүлэв.

3. Ахмадын баярын арга хэмжээнд 800.0 мянган төгрөгийг жижиг мөнгөн сангаар гарган захиран зарцуулсан алдаа зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн: Жижиг мөнгөн сангийн журмыг баримтлан ажил гүйлгээг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах, тайлагналыг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдсан алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны эрсдэлтэй байж болох байгууллагын барилгын урсгал засварын ажлын төсөв тооцоог шалгаж амжаагүй тул асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг бус хэмжээний 19026.0 мянган төгрөгийн, материаллаг бус 21050.0 мянган төгрөгийн буюу нийт 40076.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг бус хэмжээний нийт 19026.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс 19026.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгч, 21050.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох цаашид гаргахгүй байхыг анхааруулж зөвлөмж хүргүүлэв.

1. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн аудитын газраас өмнөх оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч байгууллагын удирдлагад 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Татварын хэлтсийн урсгал төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 6273.1 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний алдаа нь хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ

А.БАТЛХАГВА